


ТЕРМОДИНАМИКИЙН II ХУУЛЬ

## Second Law of Thermodynamics



Дараах процессуудаас боломжтойг нь сонгож нийтлэг чанарыг нь тодруул.

- а. Халуун биеэс хүйтэн биед дулаан шилжих
- б. Хүйтэн биеэс халуун биед дулаан аяндаа шилжих
- а. Өнхөрч байгаа бөмбөг зогсоход механик энерги дотоод энергид шилжих
- б. Тайван байгаа бөмбөг өөрөө өнхөрч дотоод энерги нь механик болон хувирах
- а. Бие өндрөөс газрын гадарга дээр унах
- б. Газрын гадарга дээр байсан бие өөрөө өндөрт хөөрөх
- а. Нэг саван дахь хоёр хий холилдох
- б. Нэг саванд холилдсон хоёр хий аяндаа ялгарах

Зөвхөн нэг чиглэлд явагдах процессуудыг үл буцах гэнэ.

Орчин тойрны биест ямар ч өөрчлөлт оруулахгүйгээр хүйтэн биеэс халуун биед дулаан шилжүүлэх боломжгүй. Үүнийг термодинамикийн 2-р хууль гэнэ. Германы эрдэмтэн Р.Клаузиус энэ хуулийг томъёолжээ.



Системийн эмх цэгцгүй, замбараагүй хэмжээсийг энтропи гэнэ.  
Термодинамик системийн энтропийн өөрчлөлт

$$\Delta S = \int \frac{dQ}{T}$$

байна.

Жишээ: 100г масстай усыг  $0^{\circ}C$ -ээс  $100^{\circ}C$  хүртэл халааж, улмаар тогтмол температурт уур болгож хувиргахад гарах энтропийн өөрчлөлтийг ол.

**БОДОЛТ:** Усыг халаахад гарах энтропийн өөрчлөлт  $\Delta S'$  ба халсан ус уур болж хувирахад гарах энтропийн өөрчлөлт  $\Delta S''$ -ийг тус тус олъё. Хоёр процессын эцэст энтропийн нийт өөрчлөлт  $\Delta S = \Delta S' + \Delta S''$  болно. Эхлээд усыг халаахад гарах энтропийн өөрчлөлтийг олъё.

$$\Delta S' = mc \ln\left(\frac{T_2}{T_1}\right)$$

. Мэдэгдэж буй тоон холбогдлыг орлуулбал:  $\Delta S' = 132 \text{ Ж/К}$   
Тогтмол температурт ус уур болоход гарах энтропийн өөрчлөлтийг

$$\Delta S'' = \frac{rm}{T}$$

. Энд:  $r$ -ууршихын хувийн дулаан.  $\Delta S'' = 605 \text{ Ж/К}$   
Энтропийн нийт өөрчлөлт  $\Delta S = \Delta S' + \Delta S'' = 737 \text{ Ж/К}$

#### ДАСГАЛ БОДЛОГО.

1. Зэсийн хайлахын дулааны тоо хэмжээ  $12980 \text{ Ж/моль}$ , зэсийн хайлах температур  $1023^{\circ}C$  бол  $63.5 \text{ г}$  зэсийн энтропийн өөрчлөлтийг тодорхойлно уу.
2.  $100 \text{ г}$  хар тугалганы хайлах температур  $327^{\circ}C$ , хайлах дулааны тоо хэмжээ  $5485 \text{ Ж/моль}$  бол хар тугалганы энтропийн өөрчлөлтийг тодорхойлно уу.
3.  $0.2 \text{ кг}$  хар тугалганы хайлах температур  $327^{\circ}C$ , хайлах дулааны тоо

хэмжээ  $6.5\text{кЖ/моль}$  бол хар тугалганы энтропийн өөрчлөлтийг тодорхойлно уу.

4. Халуун зуухнаас агаарт (хүйтэн) дулаан шилжих нь үл буцах процесс билээ. Үүний урвуу процессыг яаж явуулж болох вэ?
5.  $0.28\text{кг}$  масстай азот хийг тогтмол даралтын дор халаахад температур  $7^{\circ}\text{C}$  байснаа  $100^{\circ}\text{C}$  болтол нэмэгджээ. Азотын энтропи хичнээнээр нэмэгдсэн бэ?
6.  $300\text{К}$  температурт орших  $50\text{л}$  эзлэхүүнтэй нэг моль хийг халаахад эзлэхүүн нь 4 дахин ихсэж, температур нь  $500\text{К}$  болжээ. Хийн энтропийн өсөлтийг бопож ол.
7. Нэг моль 2 атомт идеал хий изобараар тэлж эзлэхүүн нь 2 дахин ихсэв. Хийн энтропийн өсөлтийг бопож ол.
8.  $12\text{г}$  хүчилтөрөгч изотермээр тэлж, эзлэхүүн нь  $20\text{л}$  байснаа  $50\text{л}$  болж ихсэв. Хийн энтропийн өсөлтийг бопож ол.